

БНХАУ-ЫН БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

Н.Ариунгуа*

БНХАУ сүүлийн жилүүдэд эдийн засгийн хөгжлийн асар том амжилтанд хүрч байгаа нь юуны өмнө зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт нь ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй, улс орны онцлогийг нарийн тусгасан, шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэгжиж байгаатай холбоотой юм.

Хятадын шинэчлэл нээлттэй бодлого цаг хугацааны хувьд тодорхой үе шатанд хуваагдахаас гадна мөн бүсчилсэн хэлбэрээр хэрэгжиж байгаа нь тус бодлогын онцлог хийгээд амин сүнс нь оршиж байна.

Анх бүсчилсэн хөгжлийн тухай ойлголтыг Хятадын шинэчлэлийн бодлогын эцэг Дэн Сяопин 1980 оны эхэнд шинэчлэлийн стратегийн зорилтыг үндсэн 3 үе шатанд хуваан хэрэгжүүлэхийг заагаад эхний хоёр үе шатанд далайн эрэг хавийн нутгуудийг нэн тэргүүнд хөгжүүлж 2 жилийн дотор ядууралтай тэмцэж дуусгах, 3 дахь үе шатанд төвийн бүс нутгуудад улсаас хийгээд далайн эрэг хавийн бүсүүдийн зүгээс туслалцаа дэмжлэг үзүүлэх замаар 15 жилийн дотор бүх улсын хэмжээнд шинэчлэлийн бодлогын 3 дахь үе шатыг хэрэгжүүлнэ гэж заажээ.

Эдүгээ Хятад улс бүсчилсэн хөгжлийн стратегийн хэрэгжилтийн 3 дахь үе шатандаа шилжиж байгаа бөгөөд энэ нь БНХАУ-ын баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлого юм.

Хятадын баруун бүс нутагт Синьзян-Уйгурын Өөртөө Засах Орон, Төвдийн Өөртөө Засах Орон, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шэньси, Ганьсу, Цинхай, Нинся, Сычуань, Юньнань, Гуйжоу зэрэг

10 муж, хот, өөртөө засах орон хамрагдаж байгаа ба газар нутгийн хувьд БНХАУ-ын нийт нутаг нь 56%-ийг эзэлж, хүн амын 23% багтаадаг байна. Баруун бүс нутгийн онцлог бол өргөн уудам их газартай, хүн ам сийрэг, Хятадын цөөнх үндэстнүүд оршин амьдардаг, 10 гаруй оронтой хиллэдэг, эрдэс баялгийн нөөцөөр баян онцлогтой юм. Хятадын баруун хойд бүс нутгийг баруун өмнөд хэсэгтэй харьцуулбал хөгжлийн түвшингээр их ялгаатай. 1949-1978 он хүртэл баруун бүс нутгийн ДНБ-ний жилийн дундаж 7.25 хүрч, зүүн бүс нутгийнхаас давамгайлж байсан боловч 80-аад оноос эхлэн Хятадын эдийн засгийн хөгжлийн стратеги зүүн тийш чиглэснээр баруун болон зүүн бүс нутгийн хөгжлийн түвшний ялгаа ихэссээр ирсэн юм. Иймээс ХКН-ын XV их хурлаас баруун бүсийг хөгжүүлэх шийдвэр гаргаж, 4 дахь удаагийн бүгд хурлаар баруун бүсийг хөгжүүлэх нээлттэй бодлогын стратегийг дэвшүүлэв. 1999 оны 6-р сарын 17 нд Зян Зэминь Сианьд болсон “Баруун бүсийн 5 мужийн улсын үйлдвэрүүдийг өөрчлөн хөгжүүлэх тухай” хурал дээр баруун бүс нутгийг нээлттэй болгон хөгжүүлэх нь бүх талыг хамарсан хөгжлийн стратеги бөгөөд эдийн засгийн хувьд ач холбогдолтойгоос гадна улс төр болон нийгмийн хувьд маш чухал гэж тэмдэглэжээ. Мөн энэ нь нам болон улсын чухал зорилт хэмээжээ. Энэ үеэс эхлээд БНХАУ-д баруун бүс нутгийг нээлттэй хөгжүүлэх стратегийг идэвхтэй боловсруулсан ба энэхүү төлөвлөгөөнд зааснаар: 1. баруун бүс нутгийн зам харилцаа, харилцаа холбоо усжуулалтын

* Н.Ариунгуа. ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, /Ph.D./ доктор

байгууламж дээр суурилсан бүтээн босголтыг хурдасгах, 2. байгаль орчныг нөхөн үржүүлэх зарчмыг гол болгон мод тарьж ойжуулах, баян бүрд байгуулах, тариалангийн талбайг багасгаж ойжуулах ажлыг гүйцэтгэх, 3. үйлдвэрлэлийн бүтцийг цэгцэлж ашигтай үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх замаар өвөрмөц онцлогтой эдийн засгийг бий болгох, 4. боловсрол, шинжлэх ухаан, шинэ технологийн хөгжлийг эрчимжүүлэх, улсын бус олон хэлбэрийн аж ахуйг дэмжиж, эрчимтэй хөгжүүлэх, 5. гадаадтай нээлттэй бодлого явуулж гадны хөрөнгө оруулалтыг баруун бүс нутгийг хөгжүүлэхэд оролцуулах, 6. баруун бүс нутгийг хөгжүүлэхэд зүүн бүс нутгийг өргөнөөр хамруулан оролцуулах, 7. нээлттэй бодлогын чиглэл, зорилтыг оновчтой тодорхойлох: юуны түрүүнд, баруун зүүн бүсүүдийн хөгжлийн ялгааг арилгах: хоёрдугаарт, дотооддоо шийдвэрлэвэл зохих асуудлыг түргэн шуурхай гүйцэтгэх: гуравт, үндэсний эв нэгдэл, тогтвортой байдлыг хангаж хил орчмын аюулгүй байдлыг бэхжүүлэх: дөрөвт, баруун бүс нутгийн нөөцийг нээн илрүүлэх, эдийн засгийн тасралтгүй хөгжлийг хангах: тавд, материаллаг нөөц, хүн амын хоорондын харилцааны зөрчлийг арилгаж тэнцвэржүүлэх, боловсрол, шинжлэх ухааны салбарыг хурдацтай хөгжүүлж тэдгээрийг стратегийн үндсэн чиглэл болгох юм байна.

ХКН-аас баруун бүс нутгийн стратегийн хэрэгжилтийг зохицуулахын тулд 2000 оны 2-р сараас ядууралтай тэмцэх үеийг зарласан юм. Үүний гол зорилго бол барагцаалбал 10 жилийн дотор (Хятадын хот, муж тойргуудад) бүтээн босголтын ажлыг сайжруулах, хүн амын ядуу хэсгийг чинээлэг болгох, хил хязгаар нутгийг төвхнүүлэн хөгжүүлэх, улс орны батлан хамгаалах чадавхийг сайжруулах, сайн хөршийн харилцааг бэхжүүлэх зорилготой бөгөөд үүнийгээ “хил хязгаарыг хөгжөөн, ард иргэдийг чинээлэгжүүлэх” зорилго гэж нэрлэжээ.

Баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд “4-ийг баримтлах, 7-г нэгтгэх” чиглэлийг иш үндэс болгохын чухлыг заажээ. Үүнд “4-ийг баримтлах” нь:

1. Бодит байдалд нийцүүлэн, бүх хүчээ дайчлан, урт удаан хугацаанд тэмцэл хийх оюун санааны бэлтгэлийг хангах.

2. Нарийн төлөвлөгөөтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй объектив зүй тогтлыг баримталж, нээлттэй бодлогын зорилтыг бодит зүйл болгон хэрэгжүүлэх.

3. Чухал зангилаа асуудлуудыг товойлгон гаргаж, алхам алхмаар шийдвэрлэн гол зөрчил, асуудлын гол гогцоог илрүүлэх.

4. Өөрчлөн байгуулалтыг гүнзгийрүүлэн, нээлттэй бодлогыг өргөжүүлэхдээ шинэлэг зүйл, шинэ технологид түшиглэн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй урагшлуулах.

“7-г нэгтгэх” гэдэг:

1. Ойрын төлөвлөгөөг хэтийн зорилттой уялдуулах.

2. Нээлттэй бодлогын гол зангилаа асуудлыг хөгжлийн бүхий л асуудалтай уялдуулах.

3. Зах зээлийн харилцааг өрнүүлэхдээ удирдлагын зохицуулалтыг чангатган, уялдаа холбоог сайжруулах.

4. Эдийн засгийн үр өгөөжийг нь нийгмийн талын үр нөлөө, экологийн асуудалтай уялдуулах.

5. Эдийн засгийн хөгжлийг нийгмийн дэвшилттэй хослуулах.

6. Улсын болон бусад дэмжлэг, тусламжийг баруун бүс нутгийн өөрийн бололцоо, бие даасан байдалтай хослуулах.

7. Баруун бүсийн шинэчлэлийг зүүн болон төвийн бүс нутгийн хөгжилтэй хослуулах ажээ.

Баруун бүс нутгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлэхэд Хятадын засгийн газраас хөнгөлөлттэй бодлого явуулж байгаа юм. Тухайлбал, Хятадын засгийн газраас олгодог төвийн санхүүжилтыг нэмэгдүүлэхээс гадна улсын чанартай банкны зээл олон улсын санхүүгийн байгууллага болон гадаадын

засгийн газрын хөнгөлттэй зээлийг баруун бүс нутагт илүүтэй ноогдуулан хуваарилах болжээ.

Мөн засгийн газраас баруун бүс нутагт шилжүүлэх энгийн төлбөрийн хэмжээг өргөтгөх ажээ. Тухайлбал, тариалангийн аж ахуй, нийгмийн хамгаалалт, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлаг, байгаль орчны салбарт олгодог тусгай тэтгэмжийн санхүүжилтыг баруун бүс нутагт давуутай олгохоос гадна ядууралтай тэмцэхэд зориулсан төвийн санхүүжилтыг баруун бүс нутагт голлон хэрэглэхээр болов. Үүнээс гадна Хятадын засгийн газраас санхүүгийн зээлийн дэмжлэгийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Бүс нутгийн дэд бүтцийн байгуулалтанд олгох зээлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ, биелэлтийн хугацааг харгалзан зээлийн хугацааг уртасгах бодлого хэрэгжүүлж байгаагаас гадна зээлийн хэмжээг жилээс жилд нэмэгдүүлж байна. Улсаас хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор тус бүс нутагт шинээр байгуулсан зам харилцаа, цахилгаан эрчим хүч, усан байгууламж, шуудан холбоо, радио телевизийн салбарыг эрхэлдэг аж ахуйн байгууллагыг 2 жилийн хугацаатай ашгийн татвараас чөлөөлж 3 дахь жилээс нь татварын талыг нь хураах болжээ.

Мөн байгаль орчныг хамгаалах зорилгоор тариалангийн талбайд мод тарьж орлого олж буй аж ахуйн нэгжийг 10 жилийн хугацаанд татвараас чөлөөлөх ажээ.

Уул уурхайн салбарт хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлж, газар ашиглалтын

эрхийн лицензийг 50 жилээр олгох, хугацаанд нь ашиглаж дуусвал зөвшөөрлийг сунгах буюу эрхийг залгамжлуулах ажээ.

Баруун бүс нутагт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого хэрэгжиж байгаа бөгөөд газар тариалан, усан байгууламж, экологи, зам харилцаа, цахилгаан эрчим хүч хот байгуулалт, уул уурхай, зуучлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг илүүтэй дэмжиж, урамшуулж байна. Мөн гадаад худалдааг хөхүүлэн дэмжиж бүс нутгийн үйлдвэр, аж ахуйн газруудыг гадаад худалдаа эрхлэх эрхийг өргөтгөн гадаадын байгууллагатай хамтран ажиллах, гадаадад ялангуяа хөрш улсад хөрөнгө оруулж үйлдвэр байгуулах зэргийг урамшуулах бодлогыг хэрэгжүүлж байна.

Баруун бүс нутгийг хөгжүүлэх ажил өргөн цар хүрээтэй төлөвлөгдөж байгаа бөгөөд энэхүү ажлыг хэрэгжүүлэхэд маш их хэмжээний мэргэжилтэн, боловсон хүчин шаардагдаж байгаа юм. Хятадын засгийн газраас боловсон хүчний асуудлыг хоёр замаар шийдвэрлэж байгаа ба нэгдүгээрт, орон нутгийн боловсон хүчнийг маш богино хугацаанд бэлтгэх, нөгөөтэйгүүр, Хятадын бусад нутгаас инженер, техникийн ажилтныг их хэмжээгээр оруулж ирүүлэх бодлогыг баримталж байна.

Ийнхүү баруун бүс нутгийн хөгжлийн бодлого маш эрчимтэй эхлэн хэрэгжиж, энэхүү хөгжлийн стратегийн биелэлтээс Хятад улсын цаашдын хөгжил хувь заяа ихээр хамаарах юм. Бид дараа дараагийнхаа дугаарт энэхүү бодлогод хамрагдсан нутаг, өөртөө засах орнуудад хэрхэн биеллээ олж байгаа тухай тодорхой өгүүлэх болно.